



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/407

Булган сум

Ажил эрчимжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 01 тоот албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны А/34 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны А/229 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд мал, амьтны гоц халдварт өвчний гаралт ихсэж байгаатай холбогдуулан халдварын тархалтыг зогсоох, эрсдэлийг бууруулах зорилгоор мал эмнэлгийн халдваргүйтгэлийн ажлыг шуурхай зохион байгуулсугай.

2. Мал эмнэлгийн халдваргүйтгэлийн ажлыг холбогдох хууль, журам, заавар, стандартын дагуу зохион байгуулж, таслан зогсоох арга хэмжээ авч ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т үүрэг болгосугай.

3. Дээрх ажлыг зохион байгуулахад шаардагдах 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
05 дугаар сарын 23 ны өдрийн А. /Н.О.Т. дугаар  
захирамжийн хавсралт

**МАЛ ЭМНЭЛГИЙН ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Сумын нэр	100*15 (2520төг)			Ариутгалын бодис			Нийт дүн
		Явах км	Зарцуулах шатахуун (литр)	Нийт зардал	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт	
1	2	3	4	5	6	7	8	9
1	Баян-Агт	46	5.52	13,910	50	30,000	1,500,000	1,513,910
2	Баяннуур	92	11.03	27,796	10	30,000	300,000	327,796
3	Бугат	184	22.08	55,642	10	30,000	300,000	355,642
4	Булган	262	31.44	79,229	10	30,000	300,000	379,229
5	Бүрэгхангай	262	31.44	79,229	34.5	30,000	1,035,000	1,114,229
6	Гурванбулаг	202	24.24	61,085	32	30,000	960,000	1,021,085
7	Дашинчилэн	144	17.28	43,546	30.2	30,000	906,000	949,546
8	Могод	160	19.2	48,384	30	30,000	900,000	948,384
9	Орхон	206	24.6	61,992	30	30,000	900,000	961,992
10	Сайхан	596	70	176,400	30	30,000	900,000	1,076,400
11	Сэлэнгэ	184	22	55,440	10	30,000	300,000	355,440
12	Тэшиг	160	19	47,880	30	30,000	900,000	947,880
13	Хангал	270	32	80,640	10	30,000	300,000	380,640
14	Хишиг-Өндөр	160	19	47,880	10	30,000	300,000	347,880
15	Хутаг-Өндөр	140	16	40,320	30	30,000	900,000	940,320
16	Рашаант	280	32	80,640	10	30,000	300,000	380,640
	<b>Нийт дүн</b>	<b>3348</b>	<b>396.83</b>	<b>1,000,012</b>	<b>366.7</b>		<b>11,001,000</b>	<b>12,000,000</b>